

## ТАНИЛЦУУЛГА

*Журам батлах тухай Засгийн газрын  
тогтоолын төсөл боловсруулсан тухай*

2023 оны 08 дугаар сарын 23-ны өдөр

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийг баталсан.

Энэхүү хуулийн зорилго нь төрөөс олгох ноосны, сүүний, арьс ширний, улаан буудайн, хүнсний ногооны урамшуулал авах эрх үүссэн иргэний төлбөл зохих эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн урамшууллаас нь суутган төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/58 тушаалаар журмын төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, салбар хоорондын ажлын уялдааг хангах, холбогдох чиглэл өгөх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын удирдамжийг тус тус баталсан.

Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Төрөөс олгох урамшууллаас иргэний эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг суутган төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална” гэж заасныг үндэслэн “Журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулав.

Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан хууль, тогтоомжийн дагуу төрөөс олгох ноосны, сүүний, арьс ширний, улаанбуудайн урамшууллыг жил бүр төсөвт суулган шаардлага хангасан аж ахуйн нэгж, малчин, мал бүхий иргэд, тариаланчдад олгосон. Үүнд:

1. Ноосны урамшуулалд 2020 онд 46.8 малчинд 19.4 тэрбум, 2021 онд 92.0 мянган малчинд 31.7 тэрбум төгрөг;

2. 2020 оноос шийдвэр гарч сүүний урамшуулал олгож эхэлсэн бөгөөд салбарын яам сүүний урамшууллыг литр тутамд 500 төгрөгөөр тооцож байна. 2020 оны 11 дүгээр сараас эхлээд 2021 оны 3 дугаар сар хүртэл хугацаанд 8.5 сая литр сүүг нийлүүлж, тушаасан нийт 6.5 малчин, мал бүхий иргэдэд 4.3 тэрбум төгрөг;

3. Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, “Мөнгөн урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2020 оны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн 2020 онд 797 иргэн, аж ахуйн нэгжид 22.4 тэрбум, 2021 онд 767 иргэн, аж ахуйн нэгжид 22.7 тэрбум төгрөг;

4. Арьс ширний урамшуулалд 2020 онд 37.8 мянган малчин, мал бүхий иргэдэд 9.9 тэрбум төгрөг тус тус олгосон.

Дээрх төрөөс олгож буй урамшуулалд хамрагдаж байгаа малчин, мал бүхий иргэд, тариаланчдын дийлэнх нь эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлээ байнгын орлогогүй байдлаасаа шалтгаалж төлөхгүй байна.

Төрийн зүгээс дээрх урамшуулалд жил бүр олгох мөнгөн хөрөнгийг төсөвт тусгадаг тул эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлээ тухай бүр нь тогтмол төлж чадахгүй байгаа, зарим малчин, мал бүхий иргэд, тариаланчдад төрөөс олгох урамшууллаас нь суутган тооцох нь чухал ач холбогдолтой юм. Нэн ялангуяа малчдын хувьд гар дээрээсээ шимтгэл төлөхгүйгээр ирээдүйн нийгмийн баталгаа болох тэтгэвэр, тэтгэмж төлбөр, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрх нь үүсэх юм.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөөгүй малчин, мал бүхий иргэд, тариаланчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад эдийн засгийн болон цаг хугацааны хувьд эрсдэлд орох тохиолдол ихээр тулгарч байна. Малчдын эрүүл мэндийн даатгал төлөх жилийн төлбөр нь 2019 нд 38 400 төгрөг, 2020 онд 50 400 төгрөг, 2021 онд 50 400 төгрөг, 2022 онд 50 400 төгрөг, 2023 онд 66 000 төгрөг байхаар тогтоож төлөхөөр зохицуулсан. Харин нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах малчин, мал бүхий иргэд, тариаланчдад нийгмийн даатгалын байгууллагатай тохиролцон хоёр талын гэрээ байгуулах бөгөөд гэрээнд шимтгэл тооцох сарын орлого, шимтгэл төлөх хугацаа (сар, улирал, хагас жил)-г тодорхой тусгаж өгсөн. Жишээ нь: Даатгуулагч 2023 онд сард хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 550 000 төгрөгний орлогоос тооцуулж шимтгэл төлнө гэвэл сард 74 250 төгрөг, жилд 891 000 төгрөгийг нийгмийн даатгалын санд төлнө.

2022 оны жилийн эцсийн байдлаар нийт малчдын<sup>1</sup> 12.4 хувь буюу 37.9 мянган малчин сайн дураар нийгмийн даатгалд хамрагдсан<sup>2</sup> байна.

Ноосны урамшуулал авдаг малчдын тоо нь дунджаар 66 мянга байгаагаас үүнээс эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлсөн малчин 51 мянга байдаг гэж тооцоолбол зөрүү 15 мянга гаруй малчид шимтгэлээ нөхөн төлнө. Нэг иргэний шимтгэл төлөх дүн нь тухайн жилийн шимтгэл төлөлтөөр тооцоолбол 271 200 төгрөг байгаа бөгөөд 4 068 000 000 (271 200\*15 000) төгрөгийн орлого эрүүл мэндийн даатгалын санд төвлөрөх тооцоолол байна.

Харин нийгмийн даатгалын шимтгэлээ 10 хувь буюу 6 600 иргэн төлнө гэж тооцоолбол одоогийн мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд 5 880 600 000 (74250\*6 600\*12 сар) төгрөгийн орлого нийгмийн даатгалын санд төвлөрөхөөр байна.

“Төрөөс олгох урамшууллаас иргэний эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг суутган төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журам”-ыг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсанаас хойш 2 удаа хуралдсан бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгаалын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын төлөөллүүд ажиллаж байна.

Энэхүү Засгийн газрын тогтоол батлагдсанаар улсын болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй болно.

---oOo---

---

<sup>1</sup> ҮСХ, 1212.mn

<sup>2</sup> НДЕГ